

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА**
/ 2014 оны 2 дугаар сар /

2014 он Чойр

ХҮН АМ, НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Ердийн хөдөлгөөн

Эхний 2-р сарын байдлаар аймгийн хэмжээнд 62 хүүхэд эхээс мэндэлсний 35 нь хүү, 27 нь охин байлаа . Нийт 17 хүн нас барсан байна. Бүртгүүлсэн гэр бүл 6, цуцалсан гэр бүл байхгүй , үрчлэгдсэн хүүхэд 2, Бусад аймаг нийслэлээс шилжиж ирсэн 79 , шилжин явсан иргэн 65 бүртгэгдлээ .

Төрөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,5 дахин буурсан, үзүүлэлттэй байна.

Нас баралт 17 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,8 дахин өссөн байна.

Бүртгүүлсэн гэр бүл 6 байгаа нь өмнөх оны мөн үеэс 1,5 дахин буюу 33,4 хувиар буурсан байна.

Цуцалсан гэр бүл байхгүй . Харин үрчлэгдсэн хүүхдийн тоо 2 байгаа нь өмнөх оны мөн үеэс 1 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Шинэ ажлын байр

2-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 308 байгаагаас 158 эмэгтэй буюу нийт ажилгүй иргэдийн 51,3 хувийг эзэлж байна.

Нийт ажлын байрны захиалга 51 байгаа ба мэргэжлийн салбарын ангилалаар нь авч үзвэл ХАА-н салбарт 6 , цахилгаан хий агааржуулалт 1 , усан хангамж, бохир , хог хаягдал 13 , бөөний болон жижиглэн худалдаа 8 , төрийн удирдлага 4 , боловсрол 11 , бусад салбарт 8 ажлын байрны захиалга ирсэн байна.

Мөн хугацаанд нийт 8-н иргэн ажилд зуучлагдсан ба үүнээс 7 нь буюу 87,5 хувь нь эмэгтэй байна. Ажилд зуучлагдсан иргэдийг ажил мэргэжлийн ангиллаар нь харахад менежер – 1 , мэргэжилтэн – 5 , худалдаа үйлчилгээ-1 , бусад энгийн мэргэжил -1 байна.

Халамж үйлчилгээ

Оны эхний 2-р сарын байдлаар давхардсан тоогоор 2828 хүнд 253,0 сая төгрөгийн тэтгэвэр , тэтгэмж хөнгөлөлт , халамж үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 77,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Үүнээс :

Халамжийн тэтгэвэрт	304 хүнд 68,9 сая төгрөг
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	391 хүнд 28,5 сая төгрөг
Алдарт Э/о эхчүүдийн тусламж	1104 хүнд 92,3 сая төгрөг
Ахмад настны хөнгөлөлт	427 хүнд 6,5 сая төгрөг
Хөгжлийн/ бэр иргэдийн хөнгөлөлт	51 хүнд 13,1 сая төгрөг
Жирэмсэн амаржсан	543 хүнд 42,8 сая төгрөг
Ахмад дайчдын тэтгэмж	8 хүнд 0,9 сая төгрөг
Нийт	2828 хүнд 253,0 сая төгрөгийг

халамжийн сангаас зарцуулсан байна.

ХӨДӨӨ АЖ АХУЙ

Мал төллөлт төл бойжилт

2-р сарын байдлаар төллөвөл зохих эх малын 0,9 хувь буюу 1197 мал төллөж , гарсан төл нь 1201 толгой , үүнээс 1180 төл бойжиж байна.

Мал төллөлт :

Сумд	Төллөвөл зохих хээлтэгч	Төллөсөн хээлтэгч	Төллөлтийн хувь	Хорогдсон төл	Бойжсон төл
Баянтал	18701	73	0,4	0	73
Сүмбэр	92443	1014	1,1	21	993
Шивээговь	13758	110	0,8	0	114
ДҮН	124902	1197	0,9	21	1180

Өмнөх оны мөн үеэс төл бойжилт 3,6 хувийн буурсан үзүүлэлттэй гарсан байна. Төлийн хорогдол одоогоор Сүмбэр суманд 21 хүрсэн байна .

Мал төллөлтийн байдлыг аймгийн дүнгээр таван төрөл дээр танилцуулбал :

Малын төрөл	Бүгд	Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа
Төллөсөн хээлтэгч	1197	0	2	93	867	235
Гарсан төл	1201	0	2	93	870	236
Хорогдсон төл	21	0	0	2	11	8
Бойжсон төл	1180	0	2	91	859	228

Малын хорогдол

Оны эхний 2 сарын байдлаар аймгийн хэмжээнд том малын зүй бус хорогдол 27 гарсан нь өмнөх оны мөн үеэс 87,1 хувиар буюу 7,8 дахин буурсан байна.

Том малын хорогдлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал :

Малын төрөл	2013 он	2014 он	Зөрүү
Бүгд	210	27	-183
Тэмээ	0	0	0
Адуу	6	0	-6
Үхэр	2	1	-1
Хонь	54	6	-48
Ямаа	148	20	-128

2-р сарын байдлаар ХАА-н зарим нэр төрлийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийг Сүмбэр сумын мэдээгээр харуулбал:

1. Адууны шир	27000 төгрөг
2. Үхрийн шир	27000 төгрөг
3. Хонины ноостой нэхий	5000 төгрөг
4. Ямааны ноолууртай арьс	20000 төгрөг
5. Богийн сүү, л	1500 төгрөг
6. Өндөг ш	480 төгрөг
7. Тахианы мах	5500 төгрөг
8. Гахайн мах	8500 төгрөг

АЖ ҮЙЛДВЭР

2014 оны эхний 2 сарын байдлаар аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 7024,5 сая.төгрөг, бүтээгдэхүүний нийт борлуулалт 6516,3 сая төгрөг болсон байна.

Шивээ-Овоо Хувьцаат Компани нь нийт бүтээгдэхүүний 95,0 хувийг, нийт борлуулалтын 96,1 хувийг хийсэн байна.

Шивээ-Овоо хувьцаат компани нь зах зээл дээр 1 тонн нүүрсийг 19866 төгрөгөөр худалдаалж байна.

Шивээ-Овоо хувьцаат компаний борлуулалтын үзүүлэлтийг танилцуулбал:

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Жилийн эхнээс гүйцэтгэл
Бүтээгдэхүүн борлуулалт /үнийн дүнгээр/	Сая.төг	6264,8
Нүүрс борлуулалт /биет хэмжээ/	Мян.тн	346,9
Нүүрс гаргалт /биет хэмжээ/	Мян.тн	337,3
Нийт бүтээгдэхүүн /үнийн дүнгээр/	Сая.төг	6672,9
Ажиллагсдын тоо	Хүн	515

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт / аймгийн дүнгээр / 2,4 хувиар ,
- Бүтээгдэхүүн борлуулалт /аймгийн дүнгээр/ 1,2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

ТӨСӨВ

Оны эхний 2-р сарын байдлаар орон нутгийн төсвийн орлого 831,1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 11,5 хувиар буюу 1,1 дахин буурсан байна.

Орон нутгийн орлогын гүйцэтгэлийг танилцуулбал :

/өссөн дүнгээр сая.төг/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1.Орон нутгийн орлого	1140,3	831,1
2.Татварын орлого	587,1	335,5
3.Татварын бус орлого	85,3	27,6
5.Тусламжийн орлого	467,9	467,9

Өмнөх үзүүлэлтээс дүгнэхэд орон нутгийн орлогын биелэлт 72,9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Эхний 2 сарын байдлаар аймгийн хэмжээгээр 2041,6 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 27,6 хувиар өссөн байна.

Төсвийн зарлагын гүйцэтгэлийг танилцуулбал:

/өссөн дүнгээр сая.төг/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Бүх зардал	2459,9	2041,6
Урсгал зардал	1890,6	1689,1
Хөрөнгийн зардал	-	352,5
Байгууллагын тоо	47	47
Ажиллагсадын тоо	751	751

Дээрх үзүүлэлтээс дүгнэхэд төсвийн зардал 2-р сарын байдлаар 17,0 хувийн хэмнэлттэй байна.

2 сарын байдлаар төсөвт байгууллагын:

Өглөгийн үлдэгдэл 39,9 сая төгрөг

Авлагын үлдэгдэл 16,3 сая төгрөг болоод байна.

Өглөг авлагын мэдээнээс үзэхэд өглөг нь авлагаасаа 2,4 дахин их болсон байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал авлага 2,5 дахин, өглөг 1,4 дахин өссөн үзүүлэлттэй байна.

ШУУДАН ХОЛБОО ИНТЕРНЭТ

Шуудан холбоо интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын мэдээллийг 2 сарын байдлаар авч үзвэл :

Үйлчилгээний нийт орлого 35113,0 төгрөг байна . Үүнээс 21067,0 төгрөг нь хүн амаас орсон орлого байна.

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2014 оны 2-р сар
1	Үйлчилгээний нийт орлого	Мян . төг	35113,0
2	Хүн амаас орсон орлого	Мян . төг	21067,0
3	Суурин телефон цэг	Тоо	389
4	Айл өрхөд тавьсан суурин телефоны тоо	Тоо	209

Интернэтийн хэрэглээ

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2014 оны 2-р сар
1	Интернэтийн үйлчилгээний цэгийн тоо	Тоо	2
2	Интернэтийн үйлчилгээний цэгийн суудлын тоо	ширхэг	18
3	Интернэтийн үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчдийн тоо	Тоо	450
4	Интернэтийн байнгын хэрэглэгчдийн тоо	Тоо	50

ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээнд 39 гэмт хэрэг бүртгэгдсэн ба тус гэмт хэргийн 17 нь буюу 43,6 хувь нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг байлаа. Гарсан гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 43,5 хувиар өссөн байна. Гэмт хэрэгт холбогдогсод 19, үүний 13 нь буюу 68,4 хувь нь ажилгүй иргэд байгаа ба бүгд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг байна. Гэмт хэрэгт холбогдогсод өмнөх оны мөн үетэй адил түвшинд байна

Давхардсан тоогоор 270 хүн эрүүлжүүлэгдэж , 21 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эрүүлжүүлэгдсэн хүний тоо 1,9 дахин , баривчлагдсан хүний тоо 2,1 дахин өссөн үзүүлэлт гарлаа.

Гэмт хэрэг зөрчлийг төрлөөр нь танилцуулбал:

№	Гэмт хэргийн төрөл	Хэргийн тоо		Өсөлт бууралт	
		2013 он	2014 он	тоо	хувь
1	Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг	15	17	2	11,8
2	Өмчлөх эрхийн эсрэг	1	12	11	11 дахин
3	Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	3	2	-1	-33,3
4	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2	6	4	66,6
5	Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1		-1	-100
6	Хүүхэд гэр бүлийн нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	0	1	0	1 дахин
7	Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	0	0	0	0
8	Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	0	0	0	0
9	Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	0	1	0	1 дахин
10	Бүгд	22	39	0	43,6

Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь эхний 2 сарын байдлаар 16,7 хувьтай байна.

ЦАГ УУР

2014 оны 2 дүгээр сард агаарын дундаж температур -16,6 хэм байгаа нь өмнөх оны мөн үеэс 4,2 хэмээр дулаан , хамгийн их температур -10,6 хэм, хамгийн бага температур -21,8 хэм байлаа. Хөрсний температурыг авч үзвэл дундаж нь -15,8 хэм байгаа нь өмнөх оны мөн үеэс 4,8 хэмээр дулаан, хамгийн их нь -6,4 , хамгийн бага нь -29 хэм байлаа. Тундасны хэмжээ 2,5 мм байгаа нь өмнөх оны мөн үеэс 2,5 мм-ээр их , тундастай өдрийн тоо 3 байгаа нь өмнөх оны мөн үеэс 2 дахин их байна. Салхины хурд хамгийн ихдээ 10 м/с байсан нь өмнөх оны мөн үеэс 6 м/с-р бага байна. 10 м/с –ээс дээш салхитай өдөр 1 байна. Цасан бүрхэцийн хэмжээ 7 балл , цасны зузаан 1 см байлаа . Дээрх үзүүлэлтүүдээс дүгнэхэд тайлант оны 2 дугаар сар нь өмнөх оны мөн үеэс харьцангуй дулаавтар ,тунадас ихтэй болон салхи багатай сар байв.

Статистикийн хэлтэс
2014-03-25

Хаяг: govisumber@nso.mn
Вэб: Web.nso.mn/portal

Утас:70543222, 70543017